

## 27 АРИУН СҮНС: АНХААР

### 27.1 Эзэн эдгээрийг үзэн яддаг

- Бусдын зүрх сэтгэлийг шархлуулдаг хүмүүсийг Эзэн үзэн яддаг.
- Тэр хонин сүргээс чоныг ялгаж, зайлуулна.
- Бүдүүлэг, үл хүндэтгэсэн зан байдлыг Их Эзэн үзэн яддаг. Хэрэв та нигүүлслийг хүлээн авсан бол бусдад эелдэг, хүндэтгэлтэй байгаарай
- Амьтанд хүртэл бүдүүлэг хандаж болохгүй; тэд ч бас Бурханы бүтээлүүд юм.
- Хүүхдийн боловсрол, рестораны үйл ажиллагаа, юу ч хийсэн, бүдүүлэг бус эелдэг байгаарай.

<sup>12</sup>Хорон муу хүн амнаасаа гажсан үг унаган явж,  
<sup>13</sup>Нүдээ ирмэн, хөлөөрөө дохио өгч, хуруугаараа заан,  
<sup>14</sup>Зүрхэндээ буй хар санаагаар үргэлж хорон мууг сэдэж,  
 Эвдрэлцлийг тараадаг юм.<sup>15</sup>Тиймээс сүйрэл нь гэнэт ирж,  
 Тэр даруй тэрээр эдгэшгүйгээр гэмтэнэ.

<sup>16</sup>ЭЗЭН доорх зургаан зүйлийг үзэн яддаг. Тийм ээ, эдгээр долоон зүйл Түүнд жигшил зэвүүцэл болдог. <sup>17</sup>Эдгээр нь гэвээс Ихэмсэг харц, Худалч хэл, Гэм зэмгүй цусыг урсгагч гар, <sup>18</sup>Хар буруу төлөвлөгөөг сэдэгч зүрх, Хорон муу уруу түргэн гүйгч хөл, <sup>19</sup>Худал чалчдаг хуурамч гэрчлэгч болон Ах дүүсийн дунд эвдрэлцлийг тараагч зэргүүд болой. ( Сургаалт үгс 6:12-19 АБ 2004 )

[ ] Шударга ёс гэнэт ирдэг гэдгийг та мэдэх үү?

[ ] Их Эзэний үзэн яддаг зүйлийг та үзэн яддаг уу?

### 27.2 Сайн мэдээ нь бүх хүмүүст, тэр байтугай үерт үхсэн байсан хүмүүст ч тунхагласан

<sup>6</sup>Учир нь энэ зорилгын үүднээс сайн мэдээ үхэгсдэд ч хүртэл тунхаглагдсан. Ингэснээр тэд махан биеэрээ хүмүүсийн адил шүүгдсэн боловч, Бурханы хүслийн дагуу сүнс дотор амьд байх юм. ( 1 Петр 4: 6 АБ 2004 )

## 27.3 ҮҮНИЙГ ЗААВАЛ МЭДЭЭД, СУРАЛЦАХ ЁСТОЙ

### Их Эзэний Сүнс

- Бүхнийг мэддэг, бүхнийг захирч, хаа сайгүй оршиж, мөнх байдаг мөн Бурхан болон Есүс Христтэй адил юм.
- Ариун Сүнсээр бус бол хэн ч Есүс Христийг Эзэн гэдгийг хүлээн зөвшөөрч чадахгүй.

<sup>3</sup>Тиймээс хэн ч Бурханы Сүнсээр “Есүс хараагдсан” гэж ярихгүй бөгөөд Ариун Сүнсээр бус бол өөр хэн ч “Есүс бол Эзэн” гэж хэлж чадахгүй гэдгийг би та нарт мэдэгдье.  
( 1 Коринт 12:3 АБ 2004 )

- Есүс Христийг Эзэн гэж хүлээн зөвшөөрсөн хүмүүст Есүс Ариун Сүнсээ бэлэг болгон илгээсэн юм.

<sup>15</sup>Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь. <sup>16</sup>Би Эцэгээсээ гуйхад, Тэр та нарт өөр Туслагчийг өгнө. Тэр нь та нартай үүрд хамт байна. <sup>17</sup>Тэр бол үнэний Сүнс мөн бөгөөд Түүнийг харахгүй, мэдэхгүйгээсээ болж, ертөнц Түүнийг хүлээж авч чадахгүй. Харин та нар Түүнийг мэднэ. Яагаад гэвэл Тэр та нартай хамт үргэлж байх бөгөөд та нарын дотор байна. <sup>18</sup>Би та нарыг өнчрүүлж орхихгүй. Би та нар уруу ирнэ. ( Иохан 14:15-18 АБ 2004 )

- Ариун Сүнс таньтай хамт байж таньд зааж мөн хэзээ ч орхихгүй.

<sup>1</sup>Ахлагч би сонгогдсон эзэгтэй болоод түүний хүүхдүүдэд илгээв. Би, зөвхөн би ч биш, бас үнэнийг мэддэг бүгд та нарыг үнэн дотор хайрладаг нь <sup>2</sup>бидний дотор байгаа бөгөөд бидэнтэй үүрд хамт байх үнэний төлөө юм. . ( 2 Иохан 1:1-2 АБ 2004 )

- Өөрийн дотор байгаа Ариун Сүнсийг дага

<sup>16</sup>Харин Сүнсээр яв, тэгвэл та нар махан биеийн хүслээ гүйцэлдүүлэхгүй гэж би та нарт хэлнэ. <sup>17</sup>Учир нь махан бие Сүнсний эсрэг хүсдэг, Сүнс махан биеийн эсрэг хүсдэг юм. Яагаад гэвэл хүссэн юмсыг чинь хийлгэхгүйн тулд махан бие ба Сүнс нь нэг нэгнээ эсэргүүцдэг ажээ. <sup>18</sup>Хэрэв та нар Сүнсээр удирдуулдаг бол Хуулийн дор байхгүй байна.  
( Галат 5:16-18 АБ 2004 )

<sup>19</sup>Эдүгээ махан биеийн үйлс нь илэрхий юм. Эдгээр нь завхайрал, бузар байдал, тачаангуй байдал, <sup>20</sup>шүтээн шүтэх, ид шид, дайсагнал, маргаан, хардалт, уур хилэн, өрсөлдөөн, хагарал, тэрс үзэл санаа, <sup>21</sup>атаархал, архидалт, утга учиргүй наргиж цэнгэх зэрэг нь юм. Би урьд нь та нарт сануулж байсанчлан урьдчилан сануулъя. Ийм зүйлсийг үйлдэгчид нь Бурханы хаанчлалыг өвлөхгүй. <sup>22</sup>Харин Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, <sup>23</sup>дөлгөөн зан, өөрийгөө захирах байдал нь юм. Эдгээрийн эсрэг хууль гэж байдаггүй юм. <sup>24</sup>Христ [Есүст] хамаатай хүмүүс өөрсдийн махан биеэ бузар хүсэл, тачаалынх нь хамт загалмайд цовдолсон ажээ. <sup>25</sup>Хэрэв бид Сүнс дотор амьд байгаа юм бол, мөн Сүнс дотор явцгаая. <sup>26</sup>Бид нэг нэгнээ өдөөн сөрж, өөр зуураа атаархан, сайрхахгүй байцгаая. ( Галат 5:19-26 АБ 2004 )

Махан биед нийцүүлэхийн тулд шинээр эхэлсэн Ариун Сүнсний сэргээлтээр ирэх шинэ амьдралаа дэмий бүү үр.

#### **27.4 Ариун Сүнснийг хүлээн авсан хүн хэрхэн амьдрах ёстой вэ?**

- Талархсан зүрхтэй амьдрах

<sup>20</sup>Бурхан болон Эцэгт бүхний төлөө бидний Эзэн Есүс Христийн нэрээр үргэлж талархал өргө. ( Ефес 5:20 АБ 2004)

- Баяр хөөртэй зүрхтэй амьдрах

Их олз олсон хүн шиг Би Таны үгэнд баясдаг. (Дуулал 119:162 АБ 2004 )

- Өгөгдсөн боломж бүрд үнэнийг ойлгох
- Гэрчийн амьдралаар амьдарч, гэрчлэлээ хуваалцах
- Хорон муу сүнсний уруу таталтыг эсэргүүцэж татгалзах

<sup>20</sup>Амар амгалангийн Бурхан та нарын хөл дор Сатаныг удахгүй бяцална. Бидний Эзэн Есүсийн нигүүлсэл та нартай хамт байх болтугай. (Ром 16:20 АБ 2004 )

- Эзэний ажлуудыг Бурханы тааллын дагуу хийх

<sup>11</sup>Тэд түүнийг Хурганы цус, өөрсдийн гэрчлэлийн үгээр ялжээ. Тэд үхэн үхтлээ амиа хайрлаагүй юм. ( Илчлэлт 12:11 АБ 2004 )

### **27.5 Ариун сүнсний хүчийг хэрхэн хүлээн авах вэ?**

Би Ариун Сүнсний хишгийг хэрхэн хүлээн авах вэ?

- Зүрхнийхээ хамгийн гүнээс гүн гүнзгий гэмшиж, байхгүй болгох ёстой бүх гэм нүглийг илрүүлж өгөхийг Их Эзэнээс гуйх

<sup>38</sup>Петр тэдэнд -Гэмшигтүн, хүн бүр өөрсдийн нүглийн уучлалын төлөө Есүс Христийн нэрээр баптисм хүртэцгээ. Та нар ч Ариун Сүнсний бэлгийг авах болно. ( Үйлс 2:38 АБ 2004 )

- Залбираар дамжуулан Бурханыг чин сэтгэлээсээ эрж хайх

<sup>13</sup>Учир нь Эзэн БУРХАН ийнхүү айлдахдаа “Дөчин жилийн эцэст Би египетчүүдийн тараагдсан ард түмнүүдийн дундаас тэднийг цуглуулах болно. ( Иеримиа 29:13 АБ 2004 )

- Бурханы Үгийг сонсож, суралцах

<sup>16</sup>ЭЗЭНий номноос олоод уншигтун. Тэдгээрийн нэг нь ч алга болохгүй, нэг нь ч ижлээ алдахгүй. Учир нь Түүний ам айлдаж, Түүний Сүнс тэднийг цуглуулсан юм. ( Исаиа 34:16 АБ 2004 )

Их олз олсон хүн шиг Би Таны үгэнд баясдаг. (Дуулал 119:162 АБ 2004 )

- Залбирал, итгэх, нөхөрлөх

<sup>12</sup>Тэгээд тэд Иерусалимаас холгүй байх Чидун уулаас Иерусалим уруу буцав. Тэр уул нь Иерусалимаас Амралтын өдрийн аяллын зайтай ажээ. <sup>13</sup>Тэд орж ирээд, буудаллаж байсан өрөөндөө орохоор дээшээ гарцгаав. Тэд бол Петр, Иохан, Иаков, Андрей, Филип, Томас, Бартоломай, Матай, Алфайн Иаков, Зеалотын Симон, мөн Иаковын Иуда нар болой. <sup>14</sup>Тэд хэсэг эмэгтэйчүүд, Есүсийн эх Мариа болон Түүний дүү нарын хамт нэг санаагаар байнга өөрсдийгөө залбиралд зориулж байлаа. ( Үйлс 1:12-14 АБ 2004 )

<sup>14</sup>Учир нь хэрэв бид бат итгэлийнхээ эхлэлийг эцэс хүртэл бат сахивал Христийн хуваалцагчид болсон байна. <sup>15</sup>Энэ нь “Хэрэв өнөөдөр та нар Түүний дууг сонсох аваас, Түүнийг уурлуулсны адил та нар зүрхээ бүү хатуу болго” ( Еврей 3:14-15 АБ 2004 )

<sup>23</sup>Өөрсдийн найдварын хүлээн зөвшөөрлөө гуйвалгүй бат баримталцгаая. Учир нь Амлагч нь итгэмжит билээ. <sup>24</sup>Бие биеэ хайр болон сайн үйлсэд хөхүүлэн урамшуулахад анхааръя. <sup>25</sup>Ингэхдээ зарим хүмүүсийн зуршил болсон шиг хамтран цуглахаа болилгүй, харин нөгөө өдөр ойртож буйг харах тусам бие биеэ зоригжуулъя. ( Еврей 10:23-25 АБ 2004 )

## 27.6 Анхны хайр дотроо хэрхэн үргэлжлүүлэх вэ?

- Ефес дэхь чуулган анхны хайрыг хүлээн авсан боловч үүнийгээ хэрхэн үргэлжлүүлэн сэргээж явахаа мэдээгүй.
- Таныг юу сэргээж мөн доторх Сүнсийг үргэлжлүүлэн дэмждэг болохыг олох
- Өөрийгөө цэвэрлэж Ариун Бурхантай уулзахын тулд гэмших. Ямагт залбир. Үгэн дотор суралцаж өсөх

## 27.7 Жинхэнэ итгэгч сүсэглэгч байх

<sup>1</sup>ЭЗЭН, Таны асарт хэн оршин суух вэ? Таны ариун ууланд хэн амьдран суух вэ? <sup>2</sup>Үнэнчээр явж, зөв шударгыг үйлдэж, Зүрхэндээ үнэнийг өгүүлдэг хүн. <sup>3</sup>Тэрээр хэлээрээ гүтгэдэггүй, Өөрийн анд нөхөрт ч муу юм хийдэггүй, Хөршийгөө ч эсэргүүцэн буруутгадаггүй. <sup>4</sup>Түүний нүдэнд олиггүй хүн жигшигддэг Боловч ЭЗЭНээс эмээгчдийг тэрээр хүндэлдэг юм. Тэр өөрөө хохирсон ч андгайлснаасаа няцдаггүй. <sup>5</sup>Тэр өөрийн мөнгийг хүүтэй зээлүүлдэггүй, Гэмгүй хүний эсрэг хахууль авдаг ч үгүй. Эдгээрийг үйлдэгч нь хэзээ ч ганхахгүй. ( Дуулал 15:1-5 АБ 2004 )

[ ] Та жинхэнэ сүсэглэгч мөн үү?

## 27.8 Зохистой аргаар мацаг барих

<sup>6</sup>Нүгэл хилэнцийн хүлгийг мултлан, буулганы оосрыг тайлан, дарлагдагсдыг чөлөөлж, аливаа буулгыг эвдэхийн тулд мацаг барилтыг Би сонгосон бус уу? <sup>7</sup>Өлсгөлөн нэгэнтэй талхаа хуваан, орон гэргүй ядуусыг гэртээ оруулан, нүцгэн нэгнийг хараад хувцаслаж, өөрийн цусан төрлөөс нуугдахгүй байх бус уу?<sup>8</sup>Тэгвэл чиний гэрэл үүрийн гэгээ шиг цацарч, чиний эдгэрэлт үтэр түргэн болж, чиний үнэн зөв өмнө чинь явж, ЭЗЭНий цог жавхлан чиний арын хамгаалалт болно. <sup>9</sup>Тэгэхэд чамайг дуудахад ЭЗЭН хариулж, чамайг хашхирахад Тэр “Би энд байна” гэж айлдана. Хэрэв та нар дундаасаа буулгыг зайлуулж, хуруугаараа чичлэн, зэрлэг балмад яриагаа боливол, <sup>10</sup>хэрвээ чи өлсөгчдөд өөрийгөө өгч, зовогсдын сэтгэлийг цатгавал, чиний гэрэл нь харанхуйд мандаж, чиний бүрхэг бүүдгэр нь үд дунд мэт байх болно. <sup>11</sup>ЭЗЭН чамайг ямагт удирдан, хатсан газарт чиний хүслийг хангаж, чиний ясанд тэнхээ өгнө. Чи усалсан цэцэрлэг мэт, ширгэшгүй ундаргатай булаг мэт байх болно. <sup>12</sup>Танай хүмүүс эрт цагт эвдэрсэн балгаснуудыг дахин сэргээн, олон үеийн сууриудыг босгоно. Тэгээд чамайг “Цөмөрхийг сэргээн босгогч, оршин суух гудамжийг засагч” гэж нэрлэнэ. ( Исаиа 58:6-12 АБ 2004 )

[ ] Та зохистой мацаг барьдаг уу?

[ ] Зохистой мацаг барилт ямар үр дүнтэйг та мэдэх үү?

## 27.9 Байнга итгэж, сайныг үйлдэх

<sup>1</sup>Бузар мууг үйлдэгчээс болж бүү санаа зов, Бурууг үйлдэгчдэд бүү атаарх. <sup>2</sup>Учир нь тэд өвс шиг удахгүй хатан хорчийж, Ногоон ургамал шиг хагдрах болно.

<sup>3</sup>ЭЗЭНд итгэж, сайныг үйлд. Газар нутагт оршин сууж, итгэлтэй байдлыг хоол хүнсээ болго. <sup>4</sup>ЭЗЭНд баярлагтун. Тэр чамд зүрхний чинь хүслийг өгнө.

<sup>5</sup>Өөрийн замыг ЭЗЭНд даатга, Мөн Түүнд итгэж найд. Тэгвэл Тэр биелүүлж өгнө. <sup>6</sup>Тэр чиний зөв шударгыг гэрэл мэт, Чиний шударга хэргийг үд дундын гэрэл мэт илэрхий болгоно. <sup>7</sup>ЭЗЭН дотор дуугүй байж, Түүнийг тэвчээртэйгээр хүлээ. Өөрийнхөө замаар амжилт ологчоос болон Хорон муу төлөвлөгөө биелүүлдэг хүнээс болж бүү санаа зов.

<sup>8</sup>Уурлахаа больж, хилэнгээ март. Бүү санаа зов. Энэ нь зөвхөн бузар мууг үйлдэхэд л хүргэнэ. <sup>9</sup>Бузар мууг үйлдэгчид таслагдана, Харин ЭЗЭНийг хүсэн хүлээгчид газар нутгийг өвлөх болно.

<sup>10</sup>Тун удахгүй хорон санаатан үгүй болно. Чи түүний байх газрыг анхааралтай хайх боловч Тэр байхгүй байх болно. <sup>11</sup>Харин даруу хүн газар нутгийг өвлөж, Элбэг амар амгалангаар баярлана. <sup>12</sup>Хорон муу хүн зөв шударга хүний эсрэг хуйвалдаж, Түүн уруу шүдээ хавирдаг. <sup>13</sup>Түүний өдөр ирж буйг хардаг учраас Эзэн түүнд инээдэг. <sup>14</sup>Зүдрэгсэд ба гачигдагсдыг хөсөр унагаж, Үйлсээрээ шулуун шударга хүмүүсийг алахаарХорон муу хүн илд сугалж, нумаа хөвчилжээ. <sup>15</sup>Тэдний илд өөрсдийнх нь зүрхэнд зоогдож, Нумууд нь хугарах болно.

<sup>16</sup>Зөв шударга хүний жаахан юм нь Хорон санаат олны элбэг байдлаас хавьгүй дээр юм. <sup>17</sup>Учир нь хорон санаатны гар нь хугалагдана, Харин зөв шударга хүнийг ЭЗЭН дэмждэг.

<sup>18</sup>ЭЗЭН гэм зэмгүй хүний өдрүүдийг мэддэг. Тэдний өв мөнхөд байна. <sup>19</sup>Тэд гамшгийн үед ичгүүрт орохгүй бөгөөд Өлсгөлөнгийн өдрүүдэд ч хангалуун байна. <sup>20</sup>Харин хорон муу хүн мөхнө. ЭЗЭНий дайснууд бэлчээрийн цэцгүүд мэт болж, Утаа мэт замхардаг.

<sup>21</sup>Хорон муу хүн зээлж, буцаан өгдөггүй. Харин зөв шударга хүн нигүүлсэн өгдөг. <sup>22</sup>Түүгээр ерөөгдөгсөд газар нутгийг өвлөнө, Харин Түүгээр хараагдагсад таслагдана.

<sup>23</sup>Хүний алхмууд ЭЗЭНээр тогтоогддог бөгөөд Түүний замд Тэр баярладаг. <sup>24</sup>Тэрээр бүдрэвч, газар хөсөр унахгүй. Учир нь ЭЗЭН Өөрийн гараар түүнийг түшдэг. <sup>25</sup>Би залуугаасаа хөгширтлөө Зөв шударга хүн хаягдахыг, Үр удам нь талх гуйж байхыг үзээгүй. <sup>26</sup>Тэр үргэлж нигүүлсэн хайрлаж, зээлүүлдэг. Түүний үр удам нь ерөөлтэй юм.

<sup>27</sup>Бузраас хагацаж, сайныг үйлд, Тэгвэл чи мөнхөд орших болно. <sup>28</sup>Учир нь ЭЗЭН шударга ёсыг хайрладаг бөгөөд Өөрийн бурханлаг хүмүүсийг орхидоггүй. Тэд мөнхөд хамгаалуулсан,

Харин хорон муу хүний үр удам таслагдах болно. <sup>29</sup>Зөв шударга хүн газар нутгийг өвлөж, үүнд мөнхөд оршин суух болно.

<sup>30</sup>Зөв шударга хүний ам нь мэргэн үгийг хэлдэг бөгөөд Түүний хэл нь шударга үгийг өгүүлдэг. <sup>31</sup>Түүний зүрхэнд Бурханых нь хууль оршдог. Түүний алхамд алдаа байхгүй. <sup>32</sup>Хорон муу хүн зөв шударга хүнийг анаж, Түүнийг хорлох боломжийг хайдаг. <sup>33</sup>ЭЗЭН түүнийг хорон санаатны гарт орхихгүй, Эсвэл шүүгдэх үед нь түүнийг буруушаахгүй.

<sup>34</sup>ЭЗЭНийг хүлээж, Түүний замаас бүү гар, Тэгвэл газар нутгийг өвлүүлэхээр Тэр чамайг өргөмжилнө. Хорон муу хүн таслагдахад чи үүнийг үзэх болно. <sup>35</sup>Төрөлх хөрсөндөө ургаж буй саглагар мод шиг өөрийгөө сагсайлган ургуулдаг Хорон муу, харгис хүнийг би харсан билээ. <sup>36</sup>Тэгээд тэр өнгөрсөн бөгөөд харагтун тэр алга болсон. Би түүнийг хайсан боловч тэр олдоогүй.

<sup>37</sup>Гэм зэмгүй хүнийг тэмдэглэж, Шулуун шударга хүнийг харагтун.

Учир нь амар амгалан хүн сайн сайхныг авна. <sup>38</sup>Харин нүгэлтнүүд цөмөөрөө устгагдана. Хорон муу хүний хойч үеийнхэн ч таслагдана. <sup>39</sup>Харин зөв шударга хүний аврал ЭЗЭНээс ирдэг. Тэрээр бэрх цагт тэдний хүч чадал юм. <sup>40</sup>ЭЗЭН тэдэнд тусалж, тэднийг чөлөөлдөг. Тэд Түүний дотор хоргоддог учраас Тэр тэднийг хорон муу хүнээс чөлөөлж, авардаг юм.( Дуулал 37: 1-40 АБ 2004 )

[ ] Та Эзэн дотор баярладаг уу?

[ ] Тэрээр зовлон бэрхшээлийн үед таны бат цайз байх болно гэдэгт та итгэдэг үү?

[ ] Ирээдүйд мөнх амьдрах дүр зургийг та хардаг уу?

### **27.10 Таны доторх Ариун сүнсний хүчийг юу зогсоодгийг олж мэдэх**

• Та ямар учраас дуулгаваргүй байдаг вэ? Сонгосон замаараа гүйхэд тань юу саад болдог вэ? Та юунаас болж замаа өөрчилдөг вэ?



- Их Эзэний дуу хоолойг үл ойшоох, эргэлзэх, саад тотгорыг бий болгох нь замаасаа хазайх, таниар дамжуулан Сүнсний ажиллах хүчийг сулруулдаг.

### **27.11 Ариун сүнснийг сорьсон бүхнийг зогсоо**

- Ананиа, Сапфир хоёр мэхлэхээр хуйвалдсан.
- Сүм ч бай, ажил үүрэг бай аль нь ч байсан өөрийн ашиг тусын төлөө бүү хуйвалд. Энэ бол Түүний өмнө жигшүүрт хэрэг юм.
- Бусдыг бүү хяна, бусдын хяналтанд ч бүү бай.

### **27.12 Ариун сүнгтэй хамт алхах**

Сүнсний мөрөөр явах

#### **А. Миний нэрийг дууд**

<sup>37</sup>Эзэн БУРХАН ийнхүү айлдаж байна. “Үүнийг бас тэдний төлөө хийж өгөөч гэж Надаас гуйхыг Би Израилийн гэрт зөвшөөрнө. Би тэдний хүмүүсийг хонин сүрэг адил өсгөх болно. <sup>38</sup>Тахилын төлөөх сүрэг адил, Иерусалимын тогтоогдсон наадмуудын үеэр тэнд байдаг хонин сүрэг адил нурсан хотууд хүний сүргүүдээр дүүргэгдэх болно. Тэгээд тэд Намайг ЭЗЭН мөн гэдгийг мэдэх болно” гэв. ( Езекиел 36:37 АБ 2004 )

### **27.13 Бүх зүрхээрээ асуу. Хүч нь тэр нэрнээс ирдэг.**

- Ариун Сүнсний үр жимсийг танаас хүсэн хүлээх

<sup>22</sup>Харин Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, <sup>23</sup>дөлгөөн зан, өөрийгөө захирах байдал нь юм. Эдгээрийн эсрэг хууль гэж байдаггүй юм. <sup>24</sup>Христ [Есүст] хамаатай хүмүүс өөрсдийн махан биеэ бузар хүсэл, тачаалынх нь хамт загалмайд цовдолсон ажээ. ( Галат 5:22-24 АБ 2004 )

[ ] Одоо нээлттэй болсон Библид та итгэдэг үү?

### **27.14 Ариун сүнсний үр жимсийг үргэлж гуй**

<sup>22</sup>Гуйсан болгоноо Түүнээс хүлээн авна. Учир нь бид Түүний тушаалуудыг сахиж, Түүний мэлмийд тааламжтай зүйлсийг үйлддэг билээ. <sup>23</sup>Бид Түүний Хүү Есүс Христийн нэрд итгэж, Түүний бидэнд тушаасан ёсоор бие биеэ хайрлах нь Түүний тушаал юм. <sup>24</sup>Түүний тушаалуудыг сахигч нь Түүний дотор байж, Тэр түүний дотор байна. Бидний дотор Тэр байгааг Түүний бидэнд өгсөн Сүнсээр дамжуулан бид мэддэг. (1 Иохан 3:22-24 АБ 2004 )

## **Б. Хайрлагч Бурхан зааврыг дэлгэрэнгүй өгнө .**

Тэрээр биднийг Өөртэй нь дэлгэрэнгүй ярилцаасай гэж хүсдэг. Дуулал номын 139 бясалга. Тэр бидний бодол санааг алсаас төдийгүй бидний сууж, зогсож байгааг ч мэддэг. Залбирах үедээ Бурханы хүслийг нарийвчлан илчлэхийн төлөө Түүнээс асуу. Худал шүтээнүүд таны үсний ширхэгийг тоолж чадахгүй, та хэлэхээс нааш таны бодол санааг мэдэхгүй.

### **27.15 Өөрийгөө мэдэх**

1. Надтай уулзах тэр өдөр чи тоос шороо шиг гэдгээ мэд. Эдгээр үгсийг санаж бардам биш даруу бай.

2. Бурханы ажлыг хийж завгүй байна гэж шалтаглан бие махбод, эрүүл мэндэд бүү үл хайхар.

3. Би хийж байгаа зүйлээ яагаад хийдэг гэдгээ мэдэх үү? Би яагаад шаргуу ажиллаж байгаа вэ? Мөнгөний төлөө юу? Эрүүл байхын төлөө юу? Бизнес үү? Хичээл үү? Эдгээр зүйлсийн алийг нь ч ямар шалтгаанаар хийж байгаа гэдгээ би мэдэж байгаа юу? Эдгээр нь мөнхийн зорилготой нийцэж байгаа юу?

<sup>20</sup>Юунд ч ичихгүй, харин бүрэн зоригтой байх юмсан гэсэн миний хүслэн болсон горьдлого болоод найдварын дагуу Христ одоо ч урьдын адил амиар ч бай, үхлээр ч бай бие дотор минь өргөмжлөгдөх болно. <sup>21</sup>Миний хувьд амьдрах нь Христ, үхэх нь ололт юм. <sup>22</sup>Хэрэв би махан биенд амьдрах аваас миний ажил үр жимстэй болох бөгөөд алийг нь сонгохоо би мэдэхгүй. <sup>23</sup>Гэвч би хоёр талаас шахагдаж байна. Эндээс одож, Христтэй хамт байхыг хүсэж байна. Учир нь энэ нь илүү дээр юм. <sup>24</sup>Гэвч махан биендээ үлдэх нь та нарын

тусын тулд илүү чухал байна. <sup>25</sup>Би үлдэж, та нарын итгэлийн ахиц дэвшилт болон баяр хөөрийн төлөө та бүгдтэй хамт байна гэдгээ мэдэж, үүндээ итгэлтэй байна. <sup>26</sup>Ингэснээр би та нартай дахин хамт байснаараа, надаас болж та нарын сайрхал Христ Есүсийн дотор бялхах болно. ( Филипой 1:20-26 АБ 2004 )

<sup>12</sup>Би хэдийн хүлээн авсан юм уу, эсвэл хэдийн төгс болчихсондоо биш, харин би бас Христ Есүст юуны төлөө баригдсан, түүнийг барьж авахын тулд урагшилдаг. <sup>13</sup>Ах дүү нар аа, би өөрөө хараахан барьж авсан гэж боддоггүй, харин нэг л юмыг хийдэг, ардахаа мартаж, урьдах зүйлс уруугаа зүтгэн тэмүүлж, <sup>14</sup>Христ Есүс дотор Бурханы дээш чиглэсэн дуудлагын шагналыг авахын төлөө бариа уруу урагшилдаг. <sup>15</sup>Тиймээс төлөвшсөн бид бүхэн ийм бодолтой байцгаая. Хэрэв ямар нэгэн юман дээр та нар өөр бодолтой байвал, үүнийг бас Бурхан та нарт илэрхийлнэ. <sup>16</sup>Гэвч бидэнд өгөгдсөн тэр л жишгийн дагуу явсаар байя. <sup>17</sup>Ах дүү нар аа, намайг дуурайгчид бай. Бидний та нарт үзүүлсэн жишээгээр явдаг хүмүүсийг ажигла. <sup>18</sup>Миний та нарт үргэлж ярьж байсан олон хүмүүс Христийн загалмайн дайснууд мэт явдаг гэж би одоо уйлан байж хэлж байна. <sup>19</sup>Тэдний төгсгөл бол сүйрэл. Тэдний бурхан бол ходоод бөгөөд тэд гутамшигт зүйлсээр сайрхдаг. Тэд дэлхийн юмыг л сэтгэж боддог. <sup>20</sup>Харин бидний иргэний харьяалал нь тэнгэрт байгаа бөгөөд тэндээс бид Аврагч Эзэн Есүс Христийг хүлээж байна. <sup>21</sup>Тэр бүх юмсыг Өөртөө захируулж чадах хүчээрээ бидний дорд биеийг Өөрийнхөө цог жавхланта биетэй адил болгон өөрчилнө. ( Филипой 3:12-21 АБ 2004 )

• Та нар юуны төлөө амьдарч байгаага болон яагаад хичээдэгээ мэддэг үү?

[ ] Та Бурханы тааллыг хүртэх зорилго тавьж байна уу?